



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/35/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Лхагвацэнд
Утас: 260512 Цахим хаяг: lkhagvatsendb@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэгмиддорж
Утас: 261628 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК-ын
Захирал Х.Ариунзул
Утас: 450410 Цахим хаяг: ikhnayadaudit@gmail.com

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Э.ГАНХҮҮ ТАНАА

2024.03.25 № 07/795
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэс оюу толгой ХХК нь тайлант онд санхүүжилтийн эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагаанаас бүрдүүлэх зорилтын хүрээнд Оюу толгой төсөлд хяналт тавих төслийн менежментийг сайжруулах гэрээний дагуу 17,513.1 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Аудитын гол асуудал

Толгой компани болох Эрдэнэс монгол ХХК-д төлөх зээл, зээлийн хүүгийн төлбөрөөс 1,500.0 сая төгрөгийн өр төлбөрийг төлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 388 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Z:\Yawsan_Bichig\2024\0315 SNAG-68 Docx

0001051682

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,065,257,607.77	10,646,717,728.76
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	4,804,276.17	4,779,504.38
1.1.4	Бусад авлага	11,438,087.65	3,922,161.11
1.1.6	Бараа материал		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	9,081,499,971.59	10,655,419,394.25
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	317,682,744.45	258,515,949.94
1.2.2	Биет бус хөрөнгө	34,957,627.00	34,623,075.15
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,747,782,420,000.00	2,747,782,420,000.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	101,336,195.08	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,748,236,396,566.52	2,748,075,559,025.09
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,757,317,896,538.12	2,758,730,978,419.34
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	1,937,514,102.76	3,652,566,673.62
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.6	Хүүний өглөг	5,070,986,656.53	5,070,778,341.47
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	9,744,337.00	43,172,040.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,018,245,096.29	8,766,517,055.09
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	143,616,907.69	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	7,437,342,391.16	6,237,342,391.16
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	7,580,959,298.85	6,237,342,391.16
2.2	Өр төлбөрийн нийт дүн	14,599,204,395.14	15,003,859,446.25
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:- төрийн	300,000,000.00	300,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,747,782,420,000.00	2,747,782,420,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(5,363,727,857.02)	(4,355,301,026.91)
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,742,718,692,142.98	2,743,727,118,973.09
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,757,317,896,538.12	2,758,730,978,419.34

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	20,944,418,691.82	17,513,121,763.64
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	20,944,418,691.82	17,513,121,763.64
5	Хүүний орлого		78,244,518.10
8	Бусад орлого	315,000.00	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	15,583,562,375.91	15,681,783,582.71
11	Санхүүгийн зардал	951,997,712.33	799,791,684.93
12	Бусад зардал	17,960,896.45	5,242,856.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,109,918,162.48	16,508,637.15
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	6,501,130,869.61	1,121,056,795.25
19	Орлогын татварын зардал	651,909,176.61	112,629,965.12
20	Татварын дараах ашиг (алдагдал)	5,849,221,693.00	1,008,426,830.13
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	5,849,221,693.00	1,008,426,830.13

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(9,970,512,891.66)	2,738,111,907,108.34
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(1,242,436,688.38)	(1,242,436,688.37)
Залруулсан үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(11,212,949,550.00)	2,736,869,470,550.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			5,849,221,693.00	5,849,221,693.00
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(5,363,727,857.04)	2,742,718,692,142.96
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Залруулсан үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(5,363,727,857.04)	2,742,718,692,142.96
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			1,008,426,830.13	1,008,426,830.13
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(4,355,301,026.91)	2,743,727,118,973.09

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	23,039,175,561.00	19,264,433,940.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	23,038,860,561.00	19,264,433,940.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	315,000.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	17,517,167,072.25	8,551,693,124.83
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,821,029,000.57	1,137,463,374.90
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	360,000,000.00	480,900,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	26,622,639.63	41,829,869.82
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	19,153,900.00	134,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	300,000,000.00	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	4,543,338,378.59	3,247,344,561.69
1.2.9	Бусад мөнгөн зарлага	10,447,023,153.46	3,644,021,318.42
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,522,008,488.75	10,712,740,815.17
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн		118,429,985.29
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		40,185,467.19
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		78,244,518.10
2.2	Мөнгөн зарлагын дүн	354,167,223.00	532,127,310.72
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	324,676,223.00	42,918,256.48
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	29,491,000.00	3,900,000.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		485,309,054.24
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(354,167,223.00)	(413,697,325.43)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн		1,888,320.30
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		1,888,320.30
3.2	Мөнгөн зарлагын дүн	2,876,427,369.00	8,693,699,613.59
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,100,000,000.00	8,693,699,613.59
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	219,027,369.00	
3.2.4	Төлсөн ногдол ашиг	557,400,000.00	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,876,427,369.00)	(8,691,811,293.29)
4	Валютын ханшийн зөрүү	1,424,881,474.10	(25,772,075.46)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,716,295,370.85	1,581,460,120.99
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,348,962,236.92	9,065,257,607.77
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,065,257,607.77	10,646,717,728.76

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт үйл ажиллагааны орлогын дүн	20,944,418,691.82	17,102,850,000.00	17,513,121,763.64	410,271,763.64	102.4
1.1	Ажил үйлчилгээний орлого	20,944,418,691.82	17,102,850,000.00	17,513,121,763.64	410,271,763.64	102.4
	Цалин нийгмийн хамгааллын зардал	1,476,950,193.23	2,218,007,920.00	2,161,654,438.85	56,353,481.15	97.5
2.1	Цалингийн зардал	1,243,822,693.23	1,844,880,000.00	1,830,839,159.61	14,040,840.39	99.2
2.2	Нэмэгдэл цалин	70,090,000.00	109,312,000.00	91,775,432.91	17,536,567.09	84.0
2.3	НДШ зардал	163,037,500.00	263,815,920.00	239,039,846.33	24,776,073.67	90.6
	Урсгал зардлын төсөв	13,997,190,047.49	14,769,243,698.00	14,319,920,829.00	449,322,868.79	97.0
2.4	Бичиг хэргийн зардал	9,619,000.00	12,099,100.00	9,707,536.36	2,391,563.64	80.2
2.5	Вэб сайт интернэтийн зардал	27,909,000.00	34,398,000.00	34,398,000.00	-	100.0
2.6	Шуудан холбооны зардал	3,664,000.00	30,052,629.00	8,803,276.00	21,249,353.00	29.3
2.7	Машин үйлчилгээ сэлбэг	4,230,000.00	17,600,000.00	6,989,008.32	10,610,991.68	39.7
2.8	Гэрээт ажлын зардал	125,100,000.00	226,000,000.00	226,000,000.00	-	100.0
2.9	Санхүүгийн тайлан баталгаажуулах зардал	9,900,000.00	25,000,000.00	9,900,000.00	15,100,000.00	39.6
2.10	Гадаад, дотоод сургалт, зар сурталчилгааны зардал	350,703,186.91	6,440,759,122.00	6,440,759,122.00	-	100.0
2.11	Шатахууны зардал	18,800,000.00	28,790,160.00	14,048,366.00	14,741,794	48.8
2.12	Байрны урсгал зардал	-	62,860,000.00	-	62,860,000.00	-
2.13	Зочид төлөөлөгчийн зардал	269,200,000.00	700,000,000.00	698,940,000.00	1,060,000.00	99.8
2.14	Ном, хэвлэл захиалгын зардал	2,848,500.00	8,687,481.00	4,250,000.00	4,437,481.00	48.9
2.15	Гадаад томилолтын зардал	95,849,707.00	712,060,005.00	712,060,005.00	-	100.0
2.16	Дотоод томилолтын зардал	27,250,000.00	-	-	-	-
2.17	Түрээсийн зардал	114,644,072.00	625,881,600.00	472,164,750.00	153,716,850.00	75.4
2.18	Ажилтнуудын нийгмийн асуудал, арга хэмжээ	6,780,000.00	143,260,000.00	5,242,856.00	138,017,144.00	3.7
2.19	Хангамжын материалын зардал	17,056,000.00	18,028,080.00	18,028,080.00	-	100.0
2.20	Даатгал ба эрсдэлийн зардал	8,250,000.00	15,225,000.00	226,290.91	14,998,709.09	1.5
2.21	Зөвлөх үйлчилгээ, судалгааны зардал	12,905,253,815.03	4,024,222,857.00	4,024,222,857.00	-	100.0
2.22	Боловсон хүчний аж ахуйн хангамж	-	600,000,000.00	600,000,000.00	-	100.0
2.23	Ханбогд төслийн зардал	-	130,000,000.00	130,000,000.00	-	100.0
2.24	Зээлийн хүүгийн зардал	-	800,000,000.00	800,000,000.00	-	100.0
2.25	Элэгдлийн зардал	-	114,319,664.00	104,180,681.00	10,210,983.00	91.1
2	Нийт зардлын дүн	15,474,007,474.17	16,987,251,617.00	16,481,575,268.00		96.8
3	Шаардлагатай хөрөнгө оруулалт	364,391,919.64	767,261,820.00	46,818,256.00	720,443,564.00	6.1
3.1	Компьютер, дагалдах хэрэгсэл	187,650,919.64	70,000,000.00	18,803,527.32	51,196,472.68	26.9
3.2	Тавилга, эд хогшил	-	139,327,000.00	19,108,394.16	120,218,605.84	13.7
3.3	Тоног төхөөрөмж	-	62,000,000.00	-	62,000,000.00	-
3.4	Тээврийн хэрэгсэл	147,250,000.00	400,000,000.00	-	400,000,000.00	-
3.5	Архивын программ хангамж, сервер, шаардлагатай тоног төхөөрөмж	29,491,000.00	95,934,820.00	3,545,454.55	92,389,365.45	3.7
4	Нийт дүн	15,838,399,393.81	17,754,513,437.00	16,492,998,091.00	725,804,443.97	



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн эрхэм зорилго нь "Монгол улс, ард иргэдийнхээ эрх ашгийг тэргүүн ээлжид тавьж, төслийн өгөөжийг дээшлүүлэн, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэх, удирдах эрхийг хэрэгжүүлэх" бөгөөд "Стратегийн ач холбогдол бүхий Оюу Толгой ордод үйл ажиллагаа явуулж буй "Оюу Толгой" ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших эрхийг хэрэгжүүлэх" гэсэн үндсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- "Оюу Толгой" ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших эрхийг хэрэгжүүлэх;
- Хувьцаа эзэмшигчийн хувьд "Оюу Толгой" ХХК-ийн үйл ажиллагаанд оролцох;
- Оюу Толгойн ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх;
- Төрд ногдох ашгийг төвлөрүүлэх.

Компаний улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн статустай, өмчийн 100 хувийг компанийн үүсгэн байгуулагч бөгөөд төрийн мэдлийн хувьцааг эзэмшигч "Эрдэнэс монгол" ХХК байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Эрдэнэс оюу толгой ХХК-ийг Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 348 дугаар тогтоол, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолуудыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах" гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг тус компанийн толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл томилж байгаа нь Компанийн тухай тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалттай нийцэж байна.

Эрдэнэс оюу толгой ХХК нь Ашигт малтмал түүнтэй холбоотой бусад хуулиуд, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай, Газрын хэвлийн тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын багц хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай /2023.05.04/
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай/2023.01.06/
- Нийгмийн даатгалын тухай хууль /2023.07.07/
- Татварын тухай хууль /2023.07.07/
- Төсвийн тухай хууль /2023.07.07/
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /2023.07.07/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /2023.06.16/
- Шилэн дансны тухай хууль /2023.07.07/

- Хөдөлмөрийн тухай хууль /2023.07.07/
- Төрийн хэмнэлтийн тухай хууль /2023 онд 2 удаа/
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /2023 онд 2 удаа/
- Засгийн газрын 2007 оны 354, 2011 оны 311, 2018 оны 382, 2019 оны 5, 2019 оны 7, 2023 оны 107 дугаар тогтоолууд,
- Сангийн сайдын 2006 оны 388, 2012 оны 276, 294, 2017 оны 347, 2018 оны 134, 2019 оны 190 дүгээр тушаалууд

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрдэнэс оюу толгой ХХК нь толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтлан ажиллаж байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Тайлант онд тус компани нь холбогдох стандарт, хууль дүрэм журмын дагуу өөрийн үйл ажиллагаандаа тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж эхэлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,413.1 сая төгрөгөөр буюу 0.01 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,065.3	10,646.8	1,581.5
Авлага	16.2	8.7	(7.5)
Үндсэн хөрөнгө	317.7	258.5	(59.2)
Биет бус хөрөнгө	35.0	34.6	(0.4)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,747,782.4	2,747,782.4	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	101.3	-	(101.3)
Нийт хөрөнгө	2,757,317.9	2,758,731.0	1,413.1
Богино хугацаат өр төлбөр	7,018.2	8,766.5	1,748.3
Урт хугацаат өр төлбөр	7,581.0	6,237.3	(1,343.7)
Эздийн өмч	2,742,718.7	2,743,727.1	1,008.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,757,317.9	2,758,731.0	1,413.1

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 10,646.8 сая төгрөг болж 1,581.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант жилийн үндсэн үйл ажиллагааны орлого нэмэгдсэн мөн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 258.5 сая төгрөг болж 59.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 19.1 сая төгрөгийн тавилга эд хогшил, 22.0 сая төгрөгийн компьютер дагалдах хэрэгсэл зэрэг нийт 41.1 сая төгрөгийн биет хөрөнгө худалдан авсан байна. Мөн тайлант онд 104.2 сая төгрөгийн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 10 тоот албан бичгийн дагуу 117.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэлийг Увс аймгийн Давст сумын Засаг даргын тамгын газарт шилжүүлж хассан зэрэгтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 8,766.5 сая төгрөг болж 1,748.3 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад өгөх өглөг 33.4 сая төгрөгөөр, татварын өр төлбөр 1,714.9 сая төгрөг зэргээр өссөнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 6,237.3 сая төгрөг болж 1,343.7 сая төгрөгөөр буурсан нь толгой компани болох Эрдэнэс монгол ХХК-д 1,200.0 сая төгрөгийн үндсэн зээл, 143.6 сая төгрөгийн хойшлогдсон татварын өр төлбөр хаагдсантай холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 2,743,727.1 сая төгрөг болж 1,008.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 1,008.4 сая төгрөгийн ашигтай ажилласантай холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 08 дугаар тушаалаар 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны үндсэн үйл ажиллагааны нийт орлогыг 17,102.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 16,987.3 сая төгрөгөөр, 37.0 сая төгрөгийн ашигтай

ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 767.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 17,513.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 16,446.2 сая төгрөгийн зардал гарган, 1,066.9 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 17,513.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 410.3 сая төгрөг буюу 2.4 хувиар давсан нь "Оюу Толгой" ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 274 дүгээр тогтоолын 51 дахь хэсэгт заасны дагуу Оюу Толгой төсөлд хяналт тавихад дэмжлэг үзүүлэх, төслийн менежментийг сайжруулах зорилгоор гэрээний үндсэн дээр далд уурхайн бүтээн байгуулалт ашиглалтад орох хүртэл, эсхүл "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-иас төсөлд хяналт тавих шаардлагагүй гэж үзэх хүртэл 2022 оноос эхлэн 4 жилийн хугацаанд, 1 жилд таван сая ам.доллараас ихгүй, нийт 20 сая ам.долларын санхүүжилт авах эрх зүйн орчныг бүрдүүлж ажиллах гэсэн гэрээний дагуу, тайлант онд ногдох 17,132.1 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого, Хэрлэн тооно төслийн судалгааны ажлын 381.0 сая төгрөгийн орлого орж ирсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 16,481.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 505.7 сая төгрөг буюу 2.8 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь нэмэгдэл цалин 17.5 сая төгрөг, машин засвар үйлчилгээ 10.6 сая төгрөг, шуудан холбооны зардал 21.2 сая төгрөг, шатахууны зардал 14.7 сая төгрөг, урсгал засварын зардал 62.9 сая төгрөг, түрээсийн төлбөр 153.7 сая төгрөг, ажилтнуудын нийгмийн асуудал, арга хэмжээ 138.0 сая төгрөг, даатгал ба эрсдэлийн зардал 15.0 сая төгрөг, санхүүгийн тайлан баталгаажуулах зардал 15.1 сая төгрөг, элэгдлийн зардал 10.1 сая төгрөгөөр хэмнэсэн нь нөлөөлжээ.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 4 нэр төрлийн 19.1 сая төгрөгийн тавилга эд хогшил, 3 нэр төрлийн 18.8 сая төгрөгийн компьютер, дагалдах хэрэгсэл, 3,5 сая төгрөгийн программ хангамж худалдан авсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 1,008.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 971.4 сая төгрөгөөр илүү байгаа нь тайлант оны дээрх зардлуудын хэмнэлт нөлөөлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Эрдэнэс оюу толгой ХХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторов дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн тус компанийн үйл ажиллагааг сайжруулах анхан шатны баримтын бүрдэл, шилэн дансны мэдээлэл, татварын өр төлбөрийг барагдуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Их наяд Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Мөнхзул, аудитор М.Энхтуул, Х.Ариунтуяа нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал, чанарын хяналтын менежер



Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэгмиддорж, аудитын менежер Б.Лхагвацэнд, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангаа Их наяд аудит ХХК-д 2024 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 01/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн 14,443.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 144.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.3 дахь хэсэгт заасны дагуу компанийн дэд захирал, зөвлөхийг үүрэгт ажлаас чөлөөлж, цалин хөлсний зардлыг хэмнэж, тухайн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо шинээр бий болгоогүй болно. Мөн компанийн үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлээгүй ба сургалт, семинарыг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, хэвлэл захиалга, удирдлагын харилцаа холбооны зардлыг хэмнэж, аливаа баяр ёслол, хурал зөвлөгөөн, ой тэмдэглэх зэрэг нийтийн арга хэмжээг компанийн зүгээс зохион байгуулаагүй зэрэг арга хэмжээ авсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа

Тус байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 26,899.9 сая төгрөгийн 148 мэдээлэл байршуулахаас 4,438,798.8 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээ, 474,515.9 мянган төгрөгний зарлагын 11 гүйлгээ мэдээллээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын

хариуцлагыг сайжруулах, шилэн дансанд шивсэн хэрэгжилт 65 хувьтай байгаа тул албан шаардлага хүргүүлж байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөг, цалин, орлогын дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар нийт 5,346.6 сая төгрөгийн 11 алдаа илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үзэхэд 9 алдааг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 4.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	4.6	1	4.6	100.0
Нийт дүн	1	4.6	1	4.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар шинэчлэн боловсруулж буй НБББББ нь нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байгаа эсэхийг анхаарч авч үзэх нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 791.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 741.8 сая төгрөгийн алдааг залруулж, 3.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 45.9 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй 36.5 сая төгрөгийг шууд зардалд хүлээн зөвшөөрсөн нь "үнэлгээ ба хувиарлалт", "толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.



- Хойшлогдсон татварын 245.0 сая төгрөгийн хөрөнгө, өр төлбөрийг тайлант үеийн зардалаар хүлээн зөвшөөрсөн нь “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна
- Шатахууны зарцуулалтын тооцоо хийхгүй 10.3 сая төгрөгийн шатахууны зардлыг шууд зардалд бичсэн нь “үнэлгээ ба хувиарлалт”, “толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант оны 71.1 сая төгрөгийн хүүгийн орлогыг НӨАТ тооцох орлогоор шивсэн нь “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийн хангахгүй байна.
- 2023 оны 3-р улирлын 200.0 сая төгрөгийн зээлийн хүүгийн зардлыг хүлээн зөвшөөрөөгүй нь “үнэлгээ ба хувиарлалт”, “толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Үндсэн ажилчдаас бусад гэрээтээр ажилласан хувь хүнээс суутгасан 58.6 сая төгрөгийн НДШ-ыг НДШ-ын зардлаар хүлээн зөвшөөрөөгүй нь “үнэлгээ ба хувиарлалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Оршин суугч бус этгээдээс суутгасан нэмэгдсэн өртгийн албан татварыг журналд 65.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хувиарлалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Суутган төлөгчийн аж ахуйн нэгжид олгосон орлогод ногдуулан суутгасан 42.5 сая төгрөгийн албан татварыг журналд дутуу тайлагнасан нь “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хувиарлалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Нэмэгдсэн өртгийн албан татвартай дүнгээр 12.1 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрсөн “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Залруулаагүй алдаа:

Аудитаар нийт 49.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 3.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 45.9 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Гадаад томилолтын ажлын гүйцэтгэл гараагүй, буцаан төлүүлээгүй 3.1 сая төгрөгийг зардал болгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.1.2 Томилолттой ажилтанд 0.6 сая төгрөгийн хоолны мөнгө давхардуулж олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 20.2.3-д /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/, Монгол улсын Сангийн сайдын 2020 оны “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” 120 дугаар тушаалын 1-д /Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 24,000 төгрөг,....., байрны зардлыг 40,000 төгрөг тус тус шинэчлэн баталсугай./ заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Буцаан төвлөрүүлээгүй томилолтын урьдчилгаа 3.1 сая төгрөг, хоолны мөнгө давхардуулан өгсөн 0.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Татварын 3,652.6 сая төгрөгийн өр төлбөрийн төлж барагдуулаагүй нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл. Татвар ногдуулалт, төлөлт 28.1 "Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө", Нэмэгдсэн өртгий налбан татварын тухай хуулийн 16 дугаар зүйл. Албан татвар ногдуулах, төсөвт төвлөрүүлэх, тайлагнах 16.1 "Албан татвар суутган төлөгч нь борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг доор дурдсан журмаар дараа сарын 10-ны өдрийн дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, баталсан маягтын дагуу тайлангаа харьяалах татварын албанд тушаана" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд нь татварын өр төлбөрийг барагдуулах бүрэн боломжтой тул тогтоосон хугацаанд төсөвт төлж барагдуулж байх

2. Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас баримтын бүрдэл дутуу 40.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2. "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6. "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй". гэсэн заалтуудтай нийцээгүй, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авч буй ажил үйлчилгээний төлбөр тооцоог хийхдээ хууль тогтоомжид заасан анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах;

3. Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Авлага, өр төлбөрийн үлдэгдэлгүй боловч журналд тусгахдаа харилцагчийг буруу сонгож 5.0 сая төгрөгийн гүйлгээг илүү дутуу илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлн, 20.2.5, "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцээгүй, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дансны өглөг, авлага, төлбөрийн тооцоог харилцагч бүрээр журналд тусгаж үлдэгдэлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл хөтөлдөггүй шууд зардалд хүлээн зөвшөөрсөн	1	36,547.0			1	36,547.0	1	36,547.0				
Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг тайлант үеийн зардалаар хүлээн зөвшөөрсөн	1	244,983.1			1	244,983.1	1	244,983.1				
Шатахууны зардлыг шатахууны зарцуулалтын тооцоо хийхгүй шууд зардалд бичсэн	1	10,284.4			1	10,284.4	1	10,284.4				
Тайлант оны 71.1 сая төгрөгийн хүүгийн орлогыг НӨАТ тооцох орлогоор шивсэн	1	71,094.2			1	71,094.2	1	71,094.2				
2023 оны 3-р улирлын зээлийн хүүгийн зардалыг хүлээн 1 зөвшөөрөөгүй	1	200,000.0			1	200,000.0	1	200,000.0				
Үндсэн ажилчдаас бусад гэрээтээр ажилласан хувь хүнээс суутгасан НДШ-ыг НДШ-ын зардлаар хүлээн зөвшөөрөөгүй	1	58,631.8			1	58,631.8	1	58,631.8				
Оршин суугч бус этгээдээс суутгасан НӨТ тайлан нь журналаас дутуу тайлагнасан	1	65,619.5			1	65,619.5	1	65,619.5				
Суутган төлөгчийн аж ахуйн нэгжид олгосон орлогод ногдуулан суутгасан албан татварыг журналд дутуу тайлагнасан	1	42,504.9			1	42,504.9	1	42,504.9				
Нэмэгдсэн өртгийн албан татвартай дүнгээр зардлыг хүлээн зөвшөөрсөн	1	12,139.7			1	12,139.7	1	12,139.7				
Дүн	9	791,460.6			9	791,460.6	9	791,460.6				

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гадаад томилолтын урьдчилгаа олгож, томилолтын ажлын гүйцэтгэл гараагүй, буцаан төлүүлээгүй 3.124.2 төгрөгийн авлага үүсгээгүй.	1	3,124.0	1	3,124.0								
Томилолттой ажилтанд хоолны мөнгө давхардуулж олгосон	1	642.0	1	642.0								
Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ И баримтыг дутуу бүрдүүлсэн.	1	40,890.0					1	40,890.0				
Авлага, өр төлбөрийн үлдэгдэлгүй боловч журналд тусгахдаа харилцагчийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна.	1	5,000.0					1	5,000.0				
Дүн	4	49,656.0	2	3,766.0			2	45,890.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 4,438,798.8 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээ, 474,515.9 мянган төгрөгний зарлагын 11 гүйлгээ мэдээллээгүй	1	4,913,314.7			1	4,913,314.7		
Дүн	1	4,913,314.7			1	4,913,314.7		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Татварын 3,652.6 сая төгрөгийн өр төлбөрийн төлж барагдуулаагүй байна.	1	3,652,566.7					1	3,652,566.7
Дүн	1	3,652,566.7					1	3,652,566.7
Нийт дүн	2	8,565,881.4			1	4,913,314.7	1	3,652,566.7





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 дугаар сарын 25 № 124/А0150118

Улаанбаатар хот

СНАГ-2024/35/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс оюу толгой ХХК-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Тайлант онд гадаад томилолтын ажлын гүйцэтгэл гараагүй, буцаан төлүүлээгүй 3,124,050.00 (гурван сая нэг зуун хорин дөрвөн мянга тавь) төгрөгийг зардал болгосон.
2. Томилоттой ажилтанд 642,000.00 (зургаан зуун дөчин хоёр мянга) төгрөгийн хоолны мөнгө давхардуулж олгосон

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 20.2.3-д /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/, Монгол улсын Сангийн сайдын 2020 оны "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" 120 дугаар тушаалын 1-д /Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 24,000 төгрөг,....., байрны зардлыг 40,000 төгрөг тус тус шинэчлэн баталсугай./ гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн;" заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлант онд гадаад томилолтын ажлын гүйцэтгэл гараагүй, буцаан төлүүлээгүй 3,124,050.00 (гурван сая нэг зуун хорин дөрвөн мянга тавь) төгрөгийг зардал болгосон, томилолттой ажилтанд 642,000.00 (зургаан зуун дөчин хоёр мянган) төгрөгийн хоолны мөнгийг давхардуулж олгосон зөрчлүүдийн төлбөрийг Үндэсний аудитын газрын Төрийн сан Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс оюу толгой ХХК-ны гүйцэтгэх захирал (Э.Ганхүү), нягтлан бодогч (Г.Мөнхтөр) нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
Х.АРИУНЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Ar\2024\0115 SNAG-IR Docx

0001090452



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 652/АД/ГОМБ

Улаанбаатар хот

СНАГ-2024/35/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс оюу толгой ХХК-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан аудит хийлээ. Үүнд:

Тайлан онд Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 4,438,798,780.00 (дөрвөн тэрбум дөрвөн зуун гучин найман сая долоон зуун ерэн найман мянга долоон зуун ная) төгрөгийн орлогын 3 гүйлгээ, 474,515,875.00 (дөрвөн зуун далан дөрвөн сая таван зуун арван таван мянга найман зуун далан тав) төгрөгийн зарлагын 11 гүйлгээ мэдээллээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд хугацаанд нь мэдээлэлээ бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс оюу толгой ХХК-ны гүйцэтгэх захирал (Э.Ганхүү), нягтлан бодогч (Г.Мөнхтөр) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
Х.АРИУНЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засагийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Sheardlaga\2024\0315 SNAG-31 Docs

0001080699